



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БЭРХ ХОТЫН ЗАХИРАГЧИЙН
ЗАХИРАМЖ**

2026 оны 01 сарын 27 өдөр

Дугаар А/08

Бэрх хот

Хөрөнгө зарцуулах тухай


Монгол Улсын “Хот тосгоны эрх зүйн байдлын тухай” хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалт, Захирагчийн мөрийн хөтөлбөрийн 2.2.1.2.1 дэх заалт, “Төсвийн тухай” хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1 дэх заалт, Захирагчийн зөвлөлийн 2026 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн №01 дүгээр хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хотын Захирагчийн мөрийн хөтөлбөрт тусгагдсан Багш нарын мэргэшүүлэх, чадавхыг сайжруулах ажлыг үе шаттай зохион байгуулах заалтын хүрээнд Ерөнхий боловсролын сургуулийн захирал С.Өлзийбаяр нь Солонгос улсад 7 хоногийн хугацаатай мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдаж байгаа тул 500.000 төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Дэмжлэг үзүүлэхэд шаардагдах 500.000 (Таван зуун мянга)/ төгрөгийг Мөрийн хөтөлбөрийн зардлаас зарцуулахыг Захирагчийн ажлын албаны нягтлан бодогч (Г.Осгонжаргал)-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүүгийн албаны дарга (П.Янжмаа)-д даалгасугай.

ЗАХИРАГЧ



Ч.ЭНХЖАВХЛАН

232601016